



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/48/НА-СТА-ТШЗ

| | |
|--|---|
| Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он | Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn Аудитор: М.Нарангэрэл Утас: 325093 Цахим хаяг: narangerelm@audit.gov.mn |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 328
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.МӨНХБАЯР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 223,231.8 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

D:\Desktop\2024\Word\Ресурсы\2024.02.23\Н.Модуур\хайамжийн газрын

20240223

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 86.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 14,438,541.00 | 14,506,341.00 |
| 35 | Бараа материал | 14,438,541.00 | 14,506,341.00 |
| 354 | Хангамжийн материал | 14,438,541.00 | 14,506,341.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,583,041.00 | 13,583,041.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 855,500.00 | 855,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 67,800.00 |
| 2 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 175,869,942.92 | 100,760,899.40 |
| 39 | Үндсэн хөрөнгө | 175,869,942.92 | 100,760,899.40 |
| 392 | Биет хөрөнгө | 163,606,804.29 | 91,333,335.85 |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 118,945,500.00 | - |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (87,290,117.96) | - |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 203,332,074.00 | 211,073,074.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (161,800,089.72) | (180,137,815.03) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 144,078,213.00 | 144,078,213.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (91,106,265.48) | (102,678,736.12) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 283,738,400.00 | 283,738,400.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (246,290,909.55) | (264,739,800.00) |
| 393 | Биет бус хөрөнгө | 12,263,138.63 | 9,427,563.55 |
| 39301 | Программ хангамж | 125,027,260.00 | 125,027,260.00 |
| 39302 | Хасагдуулаг | (112,764,121.37) | (116,437,121.25) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 879,296.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (41,871.20) |
| 3 | Нийт хөрөнгийн дүн | 190,308,483.92 | 115,267,240.40 |
| 5 | Цэвэр хөрөнгө, өмчийн дүн | 190,308,483.92 | 115,267,240.40 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 190,308,483.92 | 115,267,240.40 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 3,616,088.25 | 3,616,088.25 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 3,616,088.25 | 3,616,088.25 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 186,692,395.67 | 111,651,152.15 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 186,692,395.67 | 186,692,395.67 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (75,041,243.52) |
| 6 | Өр төлбөр, Цэвэр хөрөнгө өмчийн дүн | 190,308,483.92 | 115,267,240.40 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | Үйл ажиллагааны орлогын дүн (I) | 844,025,109.33 | 1,392,198,648.67 |
| 12 | Татварын бус орлого | 201,783,924.37 | 947,096.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 201,783,924.37 | 947,096.00 |
| 120 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 201,783,924.37 | 947,096.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 201,783,924.37 | 879,296.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | - | 67,800.00 |
| 13 | Тусламж, санхүүжилтийн орлого | 642,241,184.96 | 1,391,251,552.67 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 364,473,400.00 | 1,147,919,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 364,473,400.00 | 1,147,919,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 277,767,784.96 | 243,332,152.67 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө | 277,767,784.96 | 243,332,152.67 |
| 2 | Үйл ажиллагааны зардлын дүн (II) | 1,108,089,953.48 | 1,435,584,510.15 |
| 21 | Урсгал зардал | 1,108,089,953.48 | 1,435,584,510.15 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | 1,062,455,731.73 | 1,415,692,558.24 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал | 338,591,352.21 | 815,501,116.99 |
| 210101 | Цалин | 242,608,875.61 | 485,594,374.21 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 53,867,293.80 | 111,652,066.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,534,160.83 | 129,394,834.29 |
| 210104 | Урамшуулал | 17,581,021.97 | 88,552,454.42 |
| 210105 | Гэрээтийн цалин | - | 307,388.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,686,455.50 | 102,004,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 28,414,919.44 | 67,070,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,136,851.85 | 8,733,600.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,886,592.21 | 6,986,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 653,941.09 | 1,746,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 8,594,150.91 | 17,467,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 83,592,000.00 | 172,103,600.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 6,637,100.00 | - |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 5,637,500.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,410,300.00 | - |
| 210304 | Байрны түрээс | 69,907,100.00 | 172,103,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 14,544,904.67 | 13,532,635.10 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 4,774,270.00 | 3,796,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 3,724,000.00 | 1,974,670.00 |
| 210403 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 2,583,508.67 | 4,803,565.10 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 3,463,126.00 | 2,958,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,513,580.00 | 5,989,300.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 1,013,580.00 | 2,592,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | - | 490,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,500,000.00 | 2,907,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 516,624,323.38 | 253,873,448.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр | 509,033,931.38 | 243,288,152.67 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 4,000,000.00 | 8,870,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 160,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200,492.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 17,900.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 3,212,000.00 | 836,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 879,296.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,903,115.97 | 52,687,957.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 992,800.00 | 614,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 59,910,315.97 | 52,073,957.48 |
| 213 | Урсгал шилжүүлэг | 45,634,221.75 | 19,891,951.91 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,710,552.00 | 4,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 5,710,552.00 | 4,400,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 39,923,669.75 | 15,491,951.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,923,669.75 | 15,491,951.91 |
| 3 | Үйл ажиллагааны үр дүн (III=I-II) | (264,064,844.15) | (43,385,861.48) |
| 225 | Үйл ажиллагааны бус зардлын дүн (V) | 18,348,850.00 | 31,655,382.04 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 31,655,382.04 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 18,348,850.00 | - |
| 4 | Үйл ажиллагааны бус үр дүн (VI=IV-V) | (18,348,850.00) | (31,655,382.04) |
| 5 | Нийт үр дүн (VII=III+VI) | (282,413,694.15) | (75,041,243.52) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------------|---|-------------------------|-------------------------|
| 1 | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн (I) | 1,053,853,034.96 | 1,391,251,552.67 |
| 13 | Тусламж, санхүүжилтийн орлого | 1,053,853,034.96 | 1,391,251,552.67 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 364,473,400.00 | 1,147,919,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 364,473,400.00 | 1,147,919,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 689,379,634.96 | 243,332,152.67 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө | 277,767,784.96 | 243,332,152.67 |
| 131104 | Дээд шатны ТЗ-аас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны ТЗ-д олгосон хөрөнгө | 411,611,850.00 | - |
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (II) | 1,053,853,034.96 | 1,391,251,552.67 |
| 21 | Урсгал зардал | 1,053,853,034.96 | 1,391,251,552.67 |
| 210 | Бараа ажил үйлчилгээний зардал | 1,008,218,813.21 | 1,371,359,600.76 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал | 338,652,748.21 | 815,501,116.99 |
| 210101 | Үндсэн цалин | 236,193,495.22 | 485,594,374.21 |
| 210102 | Нэмэгдэл | 58,427,122.69 | 111,652,066.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,451,108.33 | 129,394,834.29 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 17,581,021.97 | 88,552,454.42 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 307,388.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,686,932.95 | 102,004,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 28,414,919.44 | 67,070,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 3,136,851.85 | 8,733,600.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 2,886,592.21 | 6,986,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 654,418.54 | 1,746,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 8,594,150.91 | 17,467,200.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 83,592,000.00 | 172,103,600.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 5,450,600.00 | - |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 6,824,000.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 1,410,300.00 | - |
| 210304 | Байрны түрээс | 69,907,100.00 | 172,103,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 10,654,108.67 | 13,588,635.10 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,119,500.00 | 3,796,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,023,000.00 | 1,974,670.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,583,508.67 | 4,803,565.10 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 112,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,816,100.00 | 3,014,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,606,900.00 | 11,750,300.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 8,106,900.00 | 8,353,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | - | 490,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,500,000.00 | 2,907,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 519,033,323.38 | 255,797,448.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний төлбөр | 510,738,931.38 | 243,232,152.67 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,000,000.00 | 8,870,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 160,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200,492.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 17,900.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,916,000.00 | 2,816,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 879,296.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 992,800.00 | 614,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 992,800.00 | 614,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 45,634,221.75 | 19,891,951.91 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,710,552.00 | 4,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 5,710,552.00 | 4,400,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 39,923,669.75 | 15,491,951.91 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 39,923,669.75 | 15,491,951.91 |
| 3 | Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ(III)=(I)-(II) | - | - |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | - | - |
| 8 | Нийт цэвэр мөнгөн гүйлгээ | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|------------|--|---------------------------------|-------------------------|--|
| C01 | 2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл | 3,616,088.25 | 1,611,579,228.68 | 1,615,195,316.93 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,616,088.25 | 1,611,579,228.68 | 1,615,195,316.93 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | (1,076,786,869.67) | (1,076,786,869.67) |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,616,088.25 | 186,692,395.67 | 190,308,483.92 |
| D01 | 2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,616,088.25 | 186,692,395.67 | 190,308,483.92 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,616,088.25 | 186,692,395.67 | 190,308,483.92 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | (75,041,243.52) | (75,041,243.52) |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл | 3,616,088.25 | 111,651,152.15 | 115,267,240.40 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|-------------------------|-------------------------|----------------------|--------------|
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 1,147,919,400.00 | 1,132,527,448.09 | 15,391,951.91 | 98.7 |
| 21 | Урсгал зардлын дүн | 1,147,919,400.00 | 1,132,527,448.09 | 15,391,951.91 | 98.7 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 1,140,044,000.00 | 1,128,127,448.09 | 11,916,551.91 | 99.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл | 816,035,400.00 | 815,501,116.99 | 534,283.01 | 99.9 |
| 210101 | Үндсэн цалин | 552,570,300.00 | 485,594,374.21 | 66,975,925.79 | 87.9 |
| 210102 | Нэмэгдэл | 184,389,800.00 | 111,652,066.07 | 72,737,733.93 | 60.6 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 47,799,000.00 | 129,394,834.29 | (81,595,834.29) | 270.7 |
| 210104 | Урамшуулал | 31,276,300.00 | 88,552,454.42 | (57,276,154.42) | 283.1 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 307,388.00 | (307,388.00) | - |
| 2102 | АО-с төлөх НДШ | 102,004,500.00 | 102,004,500.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,363,000.00 | 67,070,300.00 | 2,292,700.00 | 96.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,160,400.00 | 8,733,600.00 | (573,200.00) | 107.0 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 6,528,300.00 | 6,986,700.00 | (458,400.00) | 107.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,632,100.00 | 1,746,700.00 | (114,600.00) | 107.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,320,700.00 | 17,467,200.00 | (1,146,500.00) | 107.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 179,320,000.00 | 172,103,600.00 | 7,216,400.00 | 96.0 |
| 210304 | Байрны түрээс | 179,320,000.00 | 172,103,600.00 | 7,216,400.00 | 96.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,878,800.00 | 13,588,635.10 | 2,290,164.90 | 85.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,802,100.00 | 3,796,400.00 | 5,700.00 | 99.9 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 4,098,500.00 | 1,974,670.00 | 2,123,830.00 | 48.2 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 4,963,800.00 | 4,803,565.10 | 160,234.90 | 96.8 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 3,014,400.00 | 3,014,000.00 | 400.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 11,823,900.00 | 11,750,300.00 | 73,600.00 | 99.4 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,353,600.00 | 8,353,100.00 | 500.00 | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 490,100.00 | 490,000.00 | 100.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,980,200.00 | 2,907,200.00 | 73,000.00 | 97.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 14,001,200.00 | 12,565,296.00 | 1,435,904.00 | 89.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,243,400.00 | - | 1,243,400.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 8,883,300.00 | 8,870,000.00 | 13,300.00 | 99.9 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 78,500.00 | - | 78,500.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 87,800.00 | - | 87,800.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 8,700.00 | - | 8,700.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 2,817,100.00 | 2,816,000.00 | 1,100.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 882,400.00 | 879,296.00 | 3,104.00 | 99.6 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 980,200.00 | 614,000.00 | 366,200.00 | 62.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 980,200.00 | 614,000.00 | 366,200.00 | 62.6 |
| | Урсгал шилжүүлэг | 7,875,400.00 | 4,400,000.00 | 3,475,400.00 | 55.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,875,400.00 | 4,400,000.00 | 3,475,400.00 | 55.9 |

| | | | | | |
|--------|--|-------------------------|-------------------------|----------------------|-------------|
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 3,464,500.00 | | 3,464,500.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 4,410,900.00 | 4,400,000.00 | 10,900.00 | 99.8 |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 1,147,919,400.00 | 1,132,527,448.09 | 15,391,951.91 | 98.7 |
| 1310 | Улсын төсвөөс санхүүжих | 1,147,919,400.00 | 1,132,527,448.09 | 15,391,951.91 | 98.7 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,147,919,400.00 | 1,132,527,448.09 | 15,391,951.91 | 98.7 |
| 62 | Ажиллагсдын тоо | 40 | 37 | 3 | 92.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 34 | 32 | 2 | 94.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 4 | 1 | 80.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---------------|--|-----------------------|
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 243,332,152.67 |
| 21 | Урсгал зардлын дүн | 243,332,152.67 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 243,232,152.67 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 243,232,152.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 243,232,152.67 |
| | Урсгал шилжүүлэг | 100,000.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 100,000.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 100,000.00 |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 243,332,152.67 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 243,332,152.67 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 243,332,152.67 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 38,514.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав

Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | |
|---|------------|-----------------|-----------------------------------|-----|--------------------------|-----------------|------------|-----------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | |
| | | | | | | | Тоо | Дүн |
| Хангамжийн материалыг санхүүгийн тайланд дутуу бүртгэж тайлагнасан. | 1 | 2,075.5 | | | 1 | 2,075.5 | 1 | 2,075.5 |
| Үндсэн хөрөнгийн дансны бичилтийг буруу хийж тайлагнасан. | 1 | 7,240.0 | | | 1 | 7,240.0 | 1 | 7,240.0 |
| Тайлант онд санхүү үр дүнгийн тайланд орлогыг бууруулж бүртгэсэн | 1 | 29,199.0 | | | 1 | 29,199.0 | 1 | 29,199.0 |
| Дүн | 3 | 38,514.5 | | | 3 | 38,514.5 | 3 | 38,514.5 |

Аудитаар нийт 223,231.8 мянган төгрөгийн зөрчил² илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | | | |
|--|-------------|-----------|---------------|-----|-----------------|-----|---------|-----------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж гүйцэтгэсэн, эргэлтийн бус хөрөнгийн тооллогын дүн байвал зохих хөрөнгийн дүнгээс дутуу, эргэлтийн хөрөнгийн тооллогын дүн байвал зохих хөрөнгийн дүнгээс зөрүүтэй, тооллогыг батлагдсан маягтын дагуу хийж гүйцэтгээгүй, хөрөнгийн тооцоо бодсон акт үйлдээгүй, агуулахын бүртгэл хөтөлдөггүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийг баталсан тушаал, шийдвэр, хурлын тэмдэглэл зэрэг баримт байхгүй. | 1 | 190,980.6 | | | | | 1 | 190,980.6 |
| Тайлант онд НЗДТГ-ын санхүүжилтээр зохион байгуулсан төсөл арга хэмжээнүүдийн зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй буюу судалгааны ажлын үр дүн, үр ашиг тодорхойгүй, судлаачдын цалин хөлсний баримт байхгүй, тээвэр шатахууны зардлын нотлох баримт байхгүй, сургалтад хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн бүртгэл байхгүй. | 1 | 22,113.0 | | | | | 1 | 22,113.0 |

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | |
|--|----------|------------------|--|--|--|--|---|------------------|
| Байгууллагын тодорхой хугацааны турш хэрэгжүүлж буй хүнсний ногоо тариалах төсөл хэрэгжүүлж буй газар дээр байгаа хөрөнгийн бүртгэл, эзэмшигч нь тодорхойгүй (хүлэмж, гүний худаг, хашаа гэх мэт), байгууллагын данс бүртгэлд дутуу тусгасан байгууллагын хөрөнгийн тооллогоор тоолж баримтжуулаагүй эх үүсвэр нь тодорхойгүй. | 1 | - | | | | | 1 | - |
| Тайлант онд хангамжийн материалыг хүчин төгөлдөр нотлох баримтын шаардлага хангаагүй баримтаар ажил гүйлгээг хийж, санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. | 1 | 10,138.2 | | | | | 1 | 10,138.2 |
| Дүн | 4 | 223,231.8 | | | | | | 223,231.8 |